



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/801

Булган сум

**“Шинэ хөдөө-Сэргэлт” хөтөлбөрийг  
хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны IX/63 дугаар “Шинэ хөдөө-Сэргэлт” хөтөлбөр батлах тухай тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө-Сэргэлт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ажлыг эрчимжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)  
Гишүүд: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)  
Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)  
Б.Үүрийнтуяа (Хөдөө аж ахуйн Их сургуулийн харьяа Булган аймаг дахь Политехник коллежийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирал Сумын Засаг дарга нар  
Нарийн бичгийн дарга: Э.Уянга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

2. “Шинэ хөдөө-Сэргэлт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэхийг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР




6325011219

ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ИРГЭДИЙН НЭРС, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Өмчлөгчийн

д/д	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Хаяг	Нэгж талбарын дугаар	Өмнөх газрын хэмжээ /м2/	Өмчлөх газрын хэмжээ /м2/	Өмчилж авсан үнэ	Аймгийн Засаг даргын захирамжид өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хэсэг
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Начив онход	Зундуй	Түвшинжаргал	ЖЭ69030318	Булган сум 1 дүгээр баг Шинэ хороо 12 дугаар гудамж 1208 ТООТ	6308001855	1725	1825	6387500	Аймгийн Засаг даргын 2021 оны А/214 дугаар захирамжаас газрын хэмжээ өөрчлөх



Аймгийн Засаг даргын 2025 оны  
2 дугаар сарын 25-ныгний өдрийн  
А.18.02 дугаар захирамжийн хавсралт